



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/363

Хэрлэн сум

Сумдад ажиллахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Иргэдийн оролцоот хэтийн Хэнтий" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг иргэд олон нийтэд хүргэж, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор сумдад ажиллахад 7,886,000 (долоон сая найман зуун наян зургаан мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баярбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 23-ны өдрийн
07 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Шатахуун	436 л	2600	1136000
2.	Томилолт /5хүн/	5х15 хоног	90.000	6750000
3.	Нийт		7,886,000	